**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 30 өдөр Дугаар А/152 Номгон

"Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 90 дэх заалт, аймгийн Засаг даргын 2026 оны А/25 дугаар "Төсөл хөтөлбөр, бодлого, стратеги хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай" захирамжийн жагсаалтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах 1,000,000 (Нэг сая) төгрөгийг аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөл хөтөлбөр, бодлого, стратеги хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг тухай бүр зохион байгуулж үр дүнг тооцож ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Отгонбаяр-т даалгасугай.

ДАРГА Э.ЭНХБАТ

626010121

D:\2026\1.Zakhiramj\Zghiramj 01.docx

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 152 дугаар захирамжийн хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН БҮХ НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв мянга/төг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хугацаа | Хариуцах албан хаагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | он | Түвшин | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Зорилт Нэг.** Үндсэн хуулийг сурталчлах ажлын хүрээнд | | | | | | | | |
| 1.1. | Монгол Улсын үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, сурталчлах | - | Хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ, сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо | 2025 | 1 | 1 | 2026.01.07-2026.12.31 | ИТХ, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам |
| 1.2. | Монгол Улсын Үндсэн хуулийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | - | -Сургалт нөлөөллийн арга хэмжээний тоо<br>-Оролцогчдын тоо<br>-Мэдлэг сайжралтын хувь | 2025 | 200 | 2<br>300<br>80 хувь | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам |
| **Зорилт Хоёр.** Иргэд, төрийн албан хаагчдад эрх зүйн боловсрол олгох ажлын хүрээнд | | | | | | | | |
| 2.1. | Эрх зүйн хөтөч нар болон Насан туршийн суралцахуйн төвийн менежерүүдийг чадавхжуулах цахим сургалт түүний үр дүнг тооцох | - | -Цахим сургалтын сэдэв<br>-Оролцогчдын тоо<br>-Сэтгэл ханамжийн хувь | 2025 | 10<br>60<br>0% | 9<br>65<br>65% | 2026.01.20<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд холбогдох байгууллагын мэргэжилтнүүд |
| 2.2. | Сум, байгууллагуудын эрх зүйн хөтөч нар олон нийтийг соён гэгээрүүлэх нөлөөллийн ажлыг Насан туршийн | - | -Аймгийн нийт хүн амын 75650 хүнд | 2025 | 71505 хүнд | 72200 хүнд | 2026.01.20<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | суралцахуйн төвийн менежерүүдтэй хамтран зохион байгуулах | | эрх зүйн мэдлэг олгосон байх | | | | | холбогдох байгууллагын мэргэжилтнүүд |
| 2.3. | Эрх зүйн сурталчилгааг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх | - | -Постерийн тоо<br>-Богино видеоны тоо<br>-Подкастын тоо<br>-Цахим гарын авлага | 2025 | 20<br>5<br>0<br>0 | 25<br>10<br>2<br>1 | 2026.01.20<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд холбогдох байгууллагын мэргэжилтнүүд |
| 2.4. | Төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалтыг 3 үе шаттай зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо<br>Мэдлэг сайжралтын хувь | 2025 | 4087<br>0% | 500<br>60 хувь | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам |
| 2.5. | Төлөвлөгөөт бус сургалтыг тухай бүр зохион байгуулах | - | -Захиалга өгсөн сум байгууллагын тоо<br>-Сургалтад оролцогчдын тоо<br>-Мэдлэг сайжралтын хувь | 2025 | 89<br>7800<br>0% | 90<br>7500<br>60 хувь | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам |
| 2.6. | Шинээр томилогдсон албан хаагчдад улирал бүр цахим сургалтыг зохион байгуулах | - | -Шинээр томилогдсон албан хаагчдын тоо<br>-Сургалтын дараах сэтгэл ханамжийн хувь | 2025 | 0 | 200<br>60% | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |
| 2.7. | Зарим сумдын Иргэдийн нийтийн хуралд оролцож шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх | - | -Сумын тоо<br>-Оролцогчдын тоо | 2025 | 0 | 3<br>180 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |
| 2.8. | "Иргэдээ сонсож шийдье" нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах | - | -Өдөрлөгт оролцогч сум, байгууллагын тоо<br>-Оролцогч иргэдийн тоо | 2025 | 25<br>2000<br>100 | 30<br>2500<br>150 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Төлбөргүй үйлчилгээ авсан иргэдийн тоо | | | | | |
| 2.9. | Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын хүрээнд контент бүтээж олон нийтэд түгээх | 1 сая/төг | -Контентын үзэлт хандалтын тоо | 2025 | 0 | 5000 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд бусад оролцогчид |
| 2.10. | Захиргааны актын төслийн жишиг загвар бэлтгэж байгууллагуудад хүргүүлэх | - | -Төслийн тоо<br>-Хүлээн авсан байгууллагын тоо | 2025 | 0 | 2<br>40 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |
| 2.11. | Аймгийн албан ёсны цахим хуудсанд өөрийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг нийтлүүлэх | - | -Нийтлүүлсэн мэдээллийн тоо | 2025 | 0 | 20 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд |
| 2.12. | Аймгийн 9 багийн идэвхтэн гишүүдэд сургалт зохион байгуулах | - | -Сургалтад оролцогчдын тоо<br>-Сургалтын дараах сэтгэл ханамжийн хувь | 2025 | 0 | 80<br>50% | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд холбогдох албан хаагчид |
| 2.13. | Удирдлагуудын шуурхай хуралд оролцогчдод хууль тогтоомжийн сургалт мэдээлэл хийх | - | -Сургалт, мэдээлэлд оролцогчдын тоо<br>-Сургалт мэдээллийн тоо<br>-Сургалт, мэдээлэлд оролцогчдын сэтгэл ханамжийн хувь | 2025 | 500<br>10<br>0% | 550<br>18<br>60% | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд холбогдох албан хаагчид |
| 2.14. | Сумдын Үйлдвэрчний эвлэлийн холбоодын дарга нарт сургалт зохион байгуулах | - | -Сургалт, мэдээлэлд оролцогчдын тоо<br>-Сургалт, мэдээлэлд оролцогчдын | 2025 | 0<br>0 | 19<br>60% | 2026.02.02<br>2026.06.30 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүд Аймгийн үйлдвэрчний эвлэлийн |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сэтгэл ханамжийн хувь | | | | | холбоотой хамтран |
| 2.15. | Нотариатын үүрэг гүйцэтгэгч нарт цахим сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгөх | - | -Сургалт, мэдээлэлд оролцогчдын тоо<br>-Сургалт, мэдээлэлд оролцогчдын сэтгэл ханамжийн хувь | 2025 | 18<br>50% | 19<br>60% | 2026.02.02<br>2026.06.30 | Хэлтсийн мэргэжилтнүүд Нотариатын танхим холбогдох бусад байгууллагууд |
| **Зорилт Гурав**. Нийгмийн бүх талын идэвхтэй оролцоог хангаж, үйл ажиллагааг уялдуулах ажлын хүрээнд | | | | | | | | |
| 3.1. | “Хуулиа дээдлэгч байгууллага” арга хэмжээний хүрээнд сум, байгууллагуудын эрх зүйн ажлыг сайжруулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд оролцох | - | -Оролцогчдын тоо<br>-Сэтгэл ханамжийн хувь | 2025 | 2000<br>0 | 3000<br>60% | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв |
| 3.2. | Иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгож, үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгөх хуульчийн Про боно өдөрлөгийг зохион байгуулах | - | -Өдөрлөгт оролцогчдын тоо<br>-Ганцаарчилсан зөвлөгөө авсан иргэдийн тоо | 2025 | 280<br>50 | 300<br>60 | 2026.01.09<br>2026.12.15 | Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам |
| 3.3. | “Хуулиа дээдлэгч гэр бүл” арга хэмжээг зохион байгуулахад оролцох | - | -Оролцогч гэр бүлийн тоо<br>-Оролцогч гэр бүлийн сурталчилсан сайн туршлагын тоо | 2025 | 315<br>0 | 320<br>300 | 2026.01.09<br>2026.12.31 | Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв |
| 3.4. | “Хуулиа дээдлэгч иргэн” арга хэмжээний хүрээнд зорилтот бүлгүүдрүү чиглэсэн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад оролцох | - | -Танхимын болон цахим сургалтын тоо<br>-Сургалтад оролцогчдын тоо | 2025 | 2<br>8590 | 3<br>8600 | 2026.01.09<br>2026.12.31 | Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв, Ахмадын хороо, зөвлөл, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залуучуудын хөгжлийн зөвлөл |
| 3.5. | “Хуулиа дээдлэгч хүүхэд” арга хэмжээний хүрээнд сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулахад оролцох | - | -Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд оролцогчдын тоо<br>-Бүтээлийн тоо | 2025 | 1541<br>8 | 1550<br>9 | 2026.01.09<br>2026.12.31 | Хууль, эрх зүйн хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв |
| 3.6. | Хууль тогтоомжийг сурталчлах зөвлөн туслах ажлыг зарим сумдад зохион байгуулах | - | -Оролцогч сум, байгууллагын тоо<br>-Сургалтад хамрагдсан иргэд<br>-Албан хаагчдын тоо<br>-Мэдлэг нэмэгдсэн хувь | 2025 | 4 сум 6 байгууллага | 2 сум 12 байгууллага | 2026.01.09<br>2026.12.31 | Хууль, эрх зүйн хэлтэс, Бусад мэргэжлийн байгууллагууд |

______оОо_______